

**“Монгол-Хятадын соёл,
шинжлэх ухааны харилцаа (1949-1965)”
баримт бичгийн эмхэтгэл**

Эмхэтгэсэн: Архивын Ерөнхий Газар
ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн
Хэвлэсэн газар: Бэмби сан хэвлэлийн үйлдвэр
Хэвлэсэн он: 2021



Энэхүү баримт бичгийн эмхэтгэлийг ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Архивын ерөнхий газар хамтран ШУА байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан хэвлүүлжээ. Хоёр байгууллагын эрдэмтэн судлаачдын баг Үндэсний төв архив, Гадаад харилцааны төв архивын сан хөмрөгүүдэд баримтын судалгаа хийж, холбогдох 700 гаруй баримт бичгийг илрүүлснээс Монгол, Хятадын соёл, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагааны түүхийг цаашид дэлгэрүүлэн судлахад чухал ач холбогдолтой 229 баримтыг сонгож авч эмхэтгэлийн үндсэн болон тайлбар хэсэгт оруулжээ. Үүнд, БНМАУ ба БНХАУ-ын соёл, шинжлэх ухааны байгууллага хоорондын хамтран

ажиллах гэрээ, хэлэлцээр, протокол зэрэг удирдамжийн баримт бичгүүд; хоёр улсын соёл, урлаг, шинжлэх ухааны хамтын ажиллагааны шугамаар удирдлагын хэмжээнд харилцсан албан бичиг, захидал, уулзалтын тэмдэглэлүүд; театр, цирк, хөгжим, уран зураг, утга зохиол, сэтгүүл зүй, шинжлэх ухааны салбарын төлөөлөгчдийн харилцан айлчлал, тоглолт, туршлага судалсан, хамтран ажилласан тухай илтгэх хуудас, хэвлэлийн мэдээ, аян замын тэмдэглэл, тайлангууд; БНМАУ-аас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны соёлын арга хэмжээтэй холбогдох үйл ажиллагааны тайлан, мэдээнүүд; БНМАУ-д зохиогдож байсан Монгол-Хятадын найрамдлын 10 хоногууд, БНХАУ-д зохиогдсон Хятад-Монголын найрамдлын соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулах талаарх бэлтгэл, хэрэгжилт, дүгнэлт зэргийг багтаасан баримтууд болно. Эдгээрийн дийлэнх нь буюу 200-гаад нь анх удаа эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэнд орж байгаа юм.

Бүтцийн хувьд өмнөх үг, товчилсон үгийн жагсаалт, баримтын агуулга болон бичвэрийн тайлбар, хүний нэрсийн болон улс орон, газар усны нэрсийн хэлхээ,

хэвлэсэн баримтын жагсаалт, холбогдох гэрэл зургийн цомгоос бүрдэх нийт 443 хуудастай бөгөөд тухайн цагийн Монгол, Хятадын соёл, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагаанд холбогдох архивын баримтын анхны төрөлжсөн бүтээл болжээ.

Монгол-Хятадын шинэ үеийн соёл, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагааны эхлэл, өрнөл, хөгжлийн үйл явцыг илтгэх түүхэн эх сурвалж - архивын баримтын энэхүү эмхэтгэл уншигч таны мэдлэгийн хүрээг тэлж, судалгааны ажлын тань чухал нэгэн хэрэглэгдэхүүн болно гэдэгт итгэж байна.